



2025 оны 01 дугээр сарын 10  
№02 (1347)

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
АЛБАН МЭДЭЭЛЭЛ



**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

05. Цөмийн энергийн тухай хуульд  
заасны дагуу хөрөнгө оруулагчтай  
байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг  
зөвшилцөх дэгийн тухай 107

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

06. Стратегийн ач холбогдол бүхий ашигт  
малтмалын ордын төрийн эзэмшлийн  
хувь, хэмжээг орлуулах тухай Дугаар 01 112

۲۷۰

ଶ୍ରୀମଦ୍ଭଗବତ

۵۰- **سَعْدًا لِمَن يَخْرُجُ لِمَنْ هَمْسِلْ بِالْمِنْ حَوْلَتْسِرْسِرْ وَ**  
**سَشْتُشُو لِعَدْلَدْلَا بَعْدَشْفِيلْ مِنْ وَسْتُشْسُو لِعَدْلَدْلَا**  
**بَعْدَشْتُشِيرْ لِمَنْ دَنْنَا لَزْ كَوْلَادِسِرْ صَدَّا كَرْ حَمْسِلْ**

**بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ**

ବେଳେ କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା

go  
गो

206

三



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 01 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
 хот

### ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ БАЙГУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭГ ЗӨВШИЛЦӨХ ДЭГИЙН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т заасны дагуу зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын Засгийн газраас гадаад улсын хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл, холбогдох баримт бичгийг (цаашид “гэрээний төсөл” гэх) Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцэхээс өмнө нийт гишүүдэд тараана.

**2 дугаар зүйл.** Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо гэрээний төслийг тус тусын хуралдаанаараа урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

**3 дугаар зүйл.** Нам, эвслийн бүлэг гэрээний төслийг хэлэлцэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлж болно.

**4 дүгээр зүйл.** Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийг болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Төсвийн, Эдийн засгийн байнгын хорооны, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэнэ.

**5 дугаар зүйл.** Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд гэрээний төслийг Ерөнхий сайд, эсхүл тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн танилцуулна.

**6 дугаар зүйл.** Гэрээний төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

**7 дугаар зүйл.** Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийн талаар ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах санал, дүгнэлтийн аль нэгийг гаргана:

7.1. гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрч, тухайн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгох;

7.2.гэрээний төсөлтэй холбогдуулан хууль тогтоомжид нийцсэн зарчмын шинжтэй тодорхой засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэх;

7.3.гэрээний төслийг дэмжээгүй бол үндэслэл бүхий санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэх.

**8 дугаар зүйл.**Гэрээний төслийн агуулга, ач холбогдлыг харгалзан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гишүүдийн олонхын санаалаар гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэж болно.

**9 дүгээр зүйл.**Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэсэн бол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

**10 дугаар зүйл.**Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо нь Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын санал, дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн бол энэ тухай санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

**11 дүгээр зүйл.**Энэ хуулийн 9 болон 10 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцүүлсэн гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг дэмжсэн бол хамт оруулсан Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцно.

**12 дугаар зүйл.**Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн Засгийн газраас Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т заасны дагуу хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцэж дуустал хугацаанд дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ

ପ୍ରକାଶନ କମିଶନ - ୧୦ ଲକ୍ଷ ଟଙ୍କା

بَلْ تَعْلَمُ بِهِ وَتَعْلَمُ مَا يَعْلَمُ إِنَّمَا يَعْلَمُ مَا يَعْلَمُ مَنْ يَعْلَمُ مَا يَعْلَمُ

نیسیم . بعد دسته بیم بعده تشویه میشیم . فریبینیم که حکم زنگنه هم چندین میلیون ریالیتی شویم . نیز در پایان میتوانیم با این کارها کسب میلیونی کرد .

**بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

### Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 20<sup>1</sup>.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт байрлах MV-018916 дугаартай “Дулаан-Уул”, MV-018915 дугаартай “Зөөвч-Овоо”, MV-018914 дугаартай “Өмнөт” цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бадрах Энержи” ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулахаар тус тус тогтоосугай.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасны дагуу энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэхэд дараах зарчмыг баримтална:

1/төрийн эзэмшлийн 10 хувийн давуу эрхийн хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцүү байх;

2/нийт гаргасан энгийн болон давуу эрхийн хувьцаанд эзлэх төрийн эзэмшлийн хувь, хэмжээг 10 хувиас бууруулахгүй байх.

3.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг хавсралтаар баталсугай.

4.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



Монгол Улсын Их Хурлын 2025 оны  
01 дүгээр тогтоолын хавсралт

**АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ  
ТУСГАЙ ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ**

Ураны хүдрийн баяжмал (ураны исэл U3O8)-ын зах зээлийн үнэ (ам.доллар/фунт)	Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ
0-40 хүртэл	0.0%
40-50 хүртэл	0.5%
50-аас дээш	5.0%

---оо---

۶۰ درجه سلسیوس میباشد و در این دمای خود میتواند بسته به مقدار  
که میخواهیم میتوانیم از آن استفاده کنیم.

ପାଞ୍ଚମୀ ତଥା ଅନ୍ତର୍ମାଣରେ କିମ୍ବା ଏକାକୀଳ କାହାରେ କାହାରୁ କାହାରୁ

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ

၁၃။



О) ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ  
САЛБАРЫН АЧИГЧИЛГЭЭН ТАУЧИГИЙН  
ХААНСАН САЛБАРЫН АЧИГЧИЛГЭЭН ТАУЧИГИЙН  
ХААНСАН  
9

АЧИГЧИЛГЭЭН ТАУЧИГИЙН  
ХААНСАН САЛБАРЫН АЧИГЧИЛГЭЭН ТАУЧИГИЙН  
ХААНСАН  
9

(Англ. - English)	9-0% 0.0%
9-10 ЦИЛЯНГИ	0.1%
0-90 ЦИЛЯНГИ	0.0%

—00—

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeelel@parliament.mn](mailto:turiin_medeelel@parliament.mn)

**Үтас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

**Индекс:** 200003